



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 08 сарын 22 өдөр

Дугаар A/175

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, 271¹.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Захиргааны ерөнхий хуультай нийцүүлэх, Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 28 дугаар тэмдэглэлийг хэрэгжүүлэх зорилгоор Гаалийн ерөнхий газрын даргын 2008 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 641 дугаар тушаалын үндэслэх хэсэгт “Гаалийн тухай хуулийн 23 дугаар зүйл, Улсын гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн 2008 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь” гэж заасныг “Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, 271¹.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь” болгож өөрчилсүгэй.

2. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга /Ё.Бат-Эрдэнэ/-д, Төрийн захиргааны удирдлагын газар /Ц.Гэндэнцэвээн/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Б.АСРАЛТ



0001299